

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төс өв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.								
1.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2-т заасан Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.								
1.1.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь		Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	2025 оны 4 дүгээр сарын байдлаар Говь-Алтай аймагт нийт 364 эрүүл мэндийн байгууллагаас түүвэрлэсэн 11,933 нэхэмжлэлд нарийвчилсан хяналт шалгалт хийсэн байна. Нарийвчилсан хяналтын үр дүнд шалгуур үзүүлэлт хангаагүй 727 өвчний түүхтэй холбогдсон нийт 323.5 сая төгрөгийн нэхэмжлэлийг хүчингүй болгон, нэхэмжлэлээс хассан байна. Илэрсэн зөрчил, дутагдлын талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр мэдэгдэж, дахин зөрчил гаргахгүй байхыг анхааруулсан. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт албан ёсны зөвлөмж хүргүүлсэн бөгөөд өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүдэд сар бүр хасагдсан нэхэмжлэлийн шалтгаан болон цахим хасалтын	80

							тайлбарыг хавсаргасан албан тоотыг тогтмол хүргүүлэн ажиллаж байна.	
1.1.2	БГТ 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.		Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо		Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас гаргасан бодлого, шийдвэр, тогтоол, журмыг гэрээт 55 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, холбогдох брошюр, гарын авлагыг тараан олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Мөн 2019–2025 оны хооронд мөрдөгдөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг багтаасан брошюрыг бүх гэрээт эрүүл мэндийн байгууллагад түгээсэн. Үүний зэрэгцээ иргэд eБАРИМТ болон eMongolia аппликейшн ашиглан эрүүл мэндийн даатгалаа хэрхэн төлөх талаар мэдээлэл, зааварчилгааг хүргэж ажиллав.	80
1.1.3	“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.		Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Журмыг хэрэгжүүлж ЭМБ-д хяналт тавин ажилласан байна.	Журмыг хэрэгжүүлж ЭМБ-д хяналт тавин ажилласан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтуудад тухай бүр идэвхтэй оролцож, 2025 оны 1-р улирлын байдлаар нийт 19 удаагийн сургалтад хэлтсийн дарга, мэргэжилтэнүүд хамрагдсан. 2025 оны 3-р сард Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн “Эрүүл мэндийг дэмжих жил” уриан дор амжилттай зохион байгуулагдсан. Тус зөвлөгөөнд хэлтсийн дарга оролцож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд,	80

							<p>даатгалын төлөлт болон үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудлаар мэдээлэл хүргэв. Зөвлөгөөнд нийт 55 байгууллагын 56 төлөөлөгч хамрагдсан.</p> <p>Мөн 2025 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03, 04 дүгээр тогтоолуудад орсон өөрчлөлттэй холбоотойгоор хэлтсийн зүгээс танхимын хэлбэрээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөлд шинэчилсэн мэдээлэл, ойлголтыг өгч ажилласан.</p>	
1.1.4	<p>ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.</p>		<p>Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо</p>	<p>ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна.</p>	<p>Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлгана сан байна.</p>	<p>Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлгана сан байна.</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шинэчилсэн тогтоолыг 3 өрхийн эмнэлэг болон 19 сумын эрүүл мэндийн төвийн удирдах албан тушаалтануудад танидцуулсан.</p> <p>Тус тогтоолыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Мөн ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоолын хүрээнд хоёр удаагийн сургалтыг зохион байгуулж, аймгийн нэгдсэн эмнэлэг, уламжлалтын эмнэлэг, өрхийн болон сумын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд газар дээр нь мэдээлэл өгч, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллалаа.</p>	80
1.1.5	<p>Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо,</p>		<p>- Санхүүжүү</p>	<p>2024 онд 23208</p>	<p>ЭМБ-уудын</p>	<p>ЭМБ-уудын гүйцэтгэлд</p>	<p>Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчдын тусламж,</p>	80

	шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.		лсэн мөнгөн дүн - Хамрагдсан даатгуулагчийн тоо	иргэн 24,0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.	гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	үйлчилгээний гүйцэтгэлд чанар болон төлбөрийн хяналт тавьж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 599 иргэн хамрагдсан бөгөөд эдгээр иргэдийн тусламж, үйлчилгээний төлбөрт нийт 100,460,000 төгрөгийн санхүүжилт олгосон байна.	
1.1.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.		Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо	-	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгох санхүүжилтийн 2025 оны төсөв батлагдсан. Тайшир, Цогт, Тонхил сумдын хувьд батлагдсан төсөв нь хүрэлцээгүй байгаа тул эдгээр сумын эрүүл мэндийн байгууллагууд ЭМДЕГ-ын Бодлого, төлөвлөлтийн газарт албан хүсэлт хүргүүлж, нэмэлт санхүүжилт хүссэн. Үүний үр дүнд төсөв 17,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлагдсан болно. Мөн хэлтсийн 21 тоот дотоод албан бичгээр төсөв нь хүрэлцэхгүй байгаа Алтай Баянтоорой Гуулин Цогт Тонхил сумдын санхүүжилтийг нэмэгдүүлэх тухай хүсэлтийг дахин нэгтгэн, Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.	80
1.1.7	"ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд		Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо		Шинэчлэг дсэн журмыг ЭМБ-дад танилцуу	Шинэчлэг дсэн журмыг ЭМБ-дад танилцуу	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 сарын 17-ны 11 дүгээр тогтоолын өөрчлөлтийн хүрээнд хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх бүхий өрхийн болон сумын	80

	хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.		-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо		лж, хяналт тавин ажиллана	лж, хяналт тавин ажиллана	эмч нар, даатгалын гэрээ бүхий эмийн сангуудыг мэдээллээр хангах, мөн иргэд, даатгуулагчдад цахим хэлбэрээр мэдээлэл хүргэх, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж байна.	
1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд:								
1.4.1	Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо		Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	Салбарын хууль, тогтоол, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, сайжруулах чиглэлээр хийсэн ажлын хүрээнд холбогдох хууль, журамд оруулах саналыг тухай бүр нь боловсруулан, холбогдох газар, хэлтэст хүргүүлэн ажиллалаа. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журамд санал боловсруулж хүргүүлсэн. • "Эрүүл мэндийн даатгалын тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хуулийн төсөл болон холбогдох журамд санал өгсөн. • Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэх цуглуулах төвлөрүүлэх журамд санал өгсөн. 	80

1.4.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	Хууль хяналтын байгууллага тай хамтран 128 хүний 61018786 төгрөг ЭМД-ын санд төвлөрүүлсэн.	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	Аймгийн прокурорын газартай хамтран төр, нийтийн эрх ашгийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин болон төрийн байгууллагуудын оролцооны талаар сургалт зохион байгуулсан. Уг сургалтын хүрээнд хэлтсийн дарга 3 жилийн суурь судалгаанд үндэслэсэн тайлан, илтгэл танилцуулж, цаашид анхаарах асуудлууд болон хамтран ажиллах чиглэлээр санал солилцлоо. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хоёр удаа уулзалт хийж, 2023, 2024, 2025 оны анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тулгалтыг гүйцэтгэн, хохирлыг барагдуулаагүй гэм буруутай этгээдүүдээс албадан гүйцэтгэх ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн даатгалын сангийн хохирлыг нөхөн төлүүлэх ажлын хүрээнд 2023 онд 77 сая төгрөг, 2024 онд 69 сая төгрөг, 2025 онд 22 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажилласан байна.	80
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.								
2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд:								
2.1.1	ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5,	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд	2024 оны хамрагдалт 42 хувь	Малчдын эрүүл мэндийн даатгалд	Малчдын эрүүл мэндийн даатгалд	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/12 дугаар тушаалаар батлагдсан хамралтын төлөвлөгөөний хүрээнд 1,688	70

МУЗГҮАХ 2.1.7, БГТ-2.1.1 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.		хамрагдалтын хувь		хамрагдалтын хувь 2024 онд 50-70 хувь	хамрагдалтын хувь 2024 онд 50-70 хувь	малчныг хамруулахаар төлөвлөснөөс 989 малчин хамрагдаж, хамрагдалтын түвшин 59 хувьтай байна.		
		Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалт 149 хувь	Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100 хувь	Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100 хувь	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/12 дугаар тушаалаар батлагдсан хамралтын төлөвлөгөөний хүрээнд 250 оюутныг хамруулахаар төлөвлөснөөс 727 оюутан хамрагдаж, төлөвлөгөөний биелэлт 291 хувиар хэтэрсэн байна.	80	
		Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалт 46 хувь	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 60-80 хувь	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 60-80 хувь	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/12 дугаар тушаалаар батлагдсан хамралтын төлөвлөгөөний хүрээнд ажил хөдөлмөр эрхлээгүй 966 иргэнийг хамруулахаар төлөвлөснөөс 577 иргэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 60 хувьтай байна.	70	
		Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалт хувь 85	Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 85	Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 85	А/12 хамралтын төлөвлөгөө батлагдан хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт 7,136 байгууллага, аж ахуйн нэгж хамруулахаар төлөвлөснөөс 6,573 нь хамрагдаж, хамрагдалтын түвшин 92 хувьд хүрсэн байна.	80	
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	-	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль, журамд нийцүүлэн хугацаанд нь чанартайгаар боловсруулж, ЭМДЕГ-	80

				хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн.	хүргүүлсэн байна.	хүргүүлсэн байна.	ын Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн болно. Харин 2025 оны 1-р улиралын санхүүгийн тайлангийн нэгтгэл одоогоор программ хангамжийн хөгжүүлэлттэй холбоотойгоор түр хугацаанд хойшлогдож байна. Программ шинэчлэгдсэний дараагаар тайлангийн нэгтгэлийг үргэлжлүүлэн гүйцэтгэж, холбогдох хэлтэст хүргүүлэх болно.	
2.1.3	ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.	-	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 99,6 хувьтай байна.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газар 2025 оны 4 дүгээр улиралын байдлаар шууд орлогын төвлөрүүлэлт нийт 14.7 тэрбум төгрөгийн шууд орлогыг төвлөрүүлсэн байна. Шимтгэлээ өөрөө төлдөг даатгуулагчдын хувьд 2025 оны 4 дүгээр улирлын төлөвлөгөө 79 хувийн биелэлттэй байна. <ul style="list-style-type: none"> - Ажил олгогчийн тоо: 656 - Даатгуулагчийн тоо: 8,171 - Төсөвт байгууллагын тоо: 67 - Төсөвт байгууллагад хамрагдсан даатгуулагчийн тоо: 2,215 - Нийт цалингийн сан: 20.9 сая төгрөг - Шимтгэлд тооцсон цалингийн сан: 5.6 сая төгрөг 	80
2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан “Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална” зорилтын хүрээнд:								

2.2.1	<p>БСТ 2.2.1, БГТ-2.2.1</p> <p>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.</p>		Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	Өглөг авлаггүй ажилласан	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна	<p>Тус хэлтэс нь Говь-Алтай аймгийн хэмжээнд нийт 55 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүрээнд хамтран ажиллаж байна.</p> <p>Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хяналтыг сайтар хангах үүднээс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэнтэй сар бүр тулгалт хийж, өглөг, авлага үүсгэхгүйгээр тогтвортой ажиллаж байна.</p> <p>Мөн Капитал банкны байранд 2 түрээслэгчтэй гэрээ байгуулан байраа түрээслэж байгаа ба 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1,740,000 төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн байна. Түрээслэгчид сар бүр түрээсээ тогтмол төлж, өр, авлага үүсгээгүй болно.</p>	80
3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна								
3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна" зорилтын хүрээнд:								
3.1.1	<p>БСТ 3.1.2, БГТ 3.1.1</p> <p>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын</p>	-	Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	57 гэрээт эрүүл мэндийн байгууллага ас 30 ЭМБ гэрээ дүгнэсэн.	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/01 тоот тушаалын дагуу гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх зорилгоор ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт тус хэлтсийн дарга болон чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн нар оролцож, гэрээт байгууллагуудын	100

	2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.		Гэрээний хэрэгжилтийн хувь	Гэрээний хэрэгжилт 85 хувь	хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.	хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.	үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж ажиллалаа. Тус ажлын хэсэг нь 2024 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлыг журмын дагуу 12 дугаар сард зохион байгуулсан. Үүний хүрээнд нийт 30 эмийн сангийн гэрээг дүгнэж, Чандмань сумын эмийн санд улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн бөгөөд Тонхил сумын эмийн санд мэргэжлийн зөвлөмж өгсөн. Мөн 22 өрхийн болон сумын эрүүл мэндийн төвийн гэрээг дүгнэж, Эрдэнэ, Гуулин сумдын эрүүл мэндийн төвд зөвлөмж хүргүүлсэн.	
3.1.2	2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.		Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-3, Сумын ЭМТ-19, Эмийн сан-30 лавлагаа шатны -2	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	2025 онд тус хэлтэс нь нийт 31 эмийн сантай "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах" болон "Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх" гэрээ байгуулан ажилласан бөгөөд нэг шинэ эмийн сан шинээр нэмэгдэж, иргэдэд хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Онцлох үйл явдлын хүрээнд лавлагаа шатны хоёр эрүүл мэндийн байгууллага гэрээг цахимаар, тоон гарын үсгээр байгуулсан нь цахим шилжилтийн хүрээнд үр дүнтэй, шинэлэг ажил болсон юм. Мөн 3 өрхийн эрүүл мэндийн төв болон 19 сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан, эрүүл мэндийн даатгалын тусламж,	100

							үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлжээ. Ингэснээр нийт 55 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.	
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.		Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Гэрээт ЭМБ-ууд мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн гэрээт ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн гэрээт ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн А/30 дугаар тушаалаар хяналтын журам шинэчлэгдэн батлагдсан. Тус журмын хүрээнд лавлагаа шатны хоёр эрүүл мэндийн байгууллагад шинэчлэгдсэн журмыг танилцуулж, нэхэмжлэлд тавигдах шаардлага, нэхэмжлэл хүлээн авах үйл явц, нэхэмжлэлийг хянах маягтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Мөн 31 эмийн сан болон 22 өрхийн эрүүл мэндийн төвийг журмын талаар мэдээллээр ханган, хамтран ажилласан."	80
3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан "Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна" зорилтын хүрээнд:								
3.2.1	Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.		Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн,	Нийт 57 ЭМБ-д 3874 хүний 977,5 сая төгрөгийн хасагдал хийгдсэн.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	2025 оны 4 дүгээр сарын байдлаар Говь-Алтай аймагт нийт 364 эрүүл мэндийн байгууллагаас түүвэрлэсэн 11,933 нэхэмжлэлд нарийвчилсан хяналт шалгалт хийсэн байна. Нарийвчилсан хяналтын үр дүнд шалгуур үзүүлэлт хангаагүй 727 өвчний түүхтэй холбогдсон нийт 323.5 сая төгрөгийн нэхэмжлэлийг хүчингүй болгон, нэхэмжлэлээс хассан байна. Аймгийн гэрээт анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн	80

							байгууллагуудаас 342 хүний нийт 196,9 сая төгрөгийн санхүүжилтийг "чанар, төлбөрийн хяналт"-ын хүрээнд хассан байна. 2025 оны 3-р сарын байдлаар тус аймгийн хэмжээнд гэрээт 55 эрүүл мэндийн байгууллагад нийт 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд: 12,416 хүнд 1.1 тэрбум төгрөг • Улсын эмнэлгүүдэд: 33,258 хүнд 5.1 тэрбум төгрөг • Эмийн санд: 16,265 хүнд 674.8 сая төгрөг <p>Нийтдээ 61,939 хүн эрүүл мэндийн үйлчилгээ авсан байна.</p>	
3.2.2	БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.		Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 27 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Уламжлалт анагаах ухааны төвд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 03, 04 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрүүтэй ойлголт, санхүүжилтийн асуудал, мөн салбарт тулгамдаж буй бодит хүндрэлүүдийн талаар мэдээлэл өгч, нээлттэй ярилцлага зохион байгуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Мөн Жаргалан-Алтай, Марал-Алтай, Энх-Алтай өрхийн эрүүл мэндийн төвүүдээр орж, эрүүл мэндийн хамралт нэмэгдүүлэх, ebarimt болон бусад төрөлөөр даатгалаа хэрхэн төлөх зэрэг газар	80

							дээрх нөхцөл байдалтай танилцан, зөвлөн туслаж асуусан асуултанд хариулт өглөө	
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.		Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2024 онд нийт давхардсан тоогоор 6 эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажилласан.	Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	2025 оны 1 дүгээр улиралд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нийт 4 удаагийн зөвлөмж хүргүүлж, тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр мэргэжлийн болон арга зүйн дэмжлэгийг үзүүлэн ажиллалаа. Түүнчлэн, дээрх хугацаанд 1 эмийн санд улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг албан ёсоор хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно. Гэрээт байгууллагуудтай тогтмол харилцаа холбоотой ажиллах, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор утсаар болон биечлэн уулзалт хийж, зөвлөгөө мэдээллийг тухай бүрд нь өгч ажилласан.	80
3.2.4	БСТ 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.		Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан	2024 онд гэрээт 4 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хэлтсээс Төгрөг сумын эрүүл мэндийн төвд шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамжийг газар дээр нь үнэлэх хяналт шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн мэргэшлийн түвшин зэрэг голлох чиглэлүүдийг хамарсан болно.	80
4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.								

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

4.1.1	ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд орон сууцны хөнгөлөлт хамрагдах, сургалтанд хамрагдах	Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	<p>2025 оны 1 дүгээр сард аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээнд ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, орон нутгийн хөгжилд идэвхтэй оролцох зэрэг хэд хэдэн зорилт, арга хэмжээг тусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; • Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах; • Төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах, дэмжлэг үзүүлэх; • Ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, чадавжуулах сургалтад хамруулах; • Ажлын байрны орчны нөхцөлийг сайжруулах; • Орон нутгийн нийтийг хамарсан арга хэмжээнд байгууллагын зүгээс идэвхтэй оролцох 	80
4.1.2	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй		Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Нийт цахим сургалтанд 68 удаа хамрагдсан. Хэлтсийн зүгээс 16 удаагийн	Сургалт, сурталчилга аны арга хэмжээг зохион байгуулж,	Сургалт, сурталчилга аны арга хэмжээг зохион байгуулж,	❖ Аймгийн хэмжээнд 2025 оны 5 дугаар сард төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд “Хуульчийн про боно 2025” нэртэй нээлттэй өдөрлөг амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын хэлтэс идэвхтэй	80

	<p>өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.</p>			<p>сургалт танхимаар хийсэн.</p>	<p>тайлагнасан байна.</p>	<p>тайлагнасан байна.</p>	<p>оролцож, иргэдэд эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээ, мэдээллийг хүргэн, үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлан ажиллав. - Эрүүл мэндийн даатгалын талаар иргэдэд ерөнхий мэдээлэл өгөх, - Даатгуулах үйл явц, эрх, үүрэг, давуу талын талаар зөвлөгөө өгөх, - гарын авлага, танилцуулга материалыг тараах замаар мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, - иргэдийн асуултад хариу өгч, зөвлөгөө өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын даргын сумдад ажиллах үеэр Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс холбогдох мэдээллийг боловсруулан танилцуулсан. Тус танилцуулгын хүрээнд: ❖ Аймгийн 19 сумыг хамарсан сум бүрийн 2024 оны эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь болон 2025 онд хамруулах зорилтот төлөвлөгөө-г нарийвчлан боловсруулж, удирдлагуудад танилцуулсан. ❖ Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд эрүүл мэндийн даатгалын хамралтыг 80 хувиас дээш түвшинд хүргэх зорилтыг тусган ажиллаж байна. Энэ 	
--	--	--	--	----------------------------------	---------------------------	---------------------------	---	--

							<p>хүрээнд сум орон нутгийн удирдлагууд, эрүүл мэндийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх, даатгалын үйлчилгээнд иргэдийг идэвхтэй хамруулах арга хэмжээг зохион байгуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан 19 удаагийн цахим сургалт болон бусад төрлийн сургалтуудад тухай бүр тогтмол оролцож, мэдээ мэдээлэл авч ажиллаж байна. ❖ Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг” 380км зайд зохион байгуулагдлаа. ❖ 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Овгор Шар гэдэг газарт “Нээлттэй хаалганы өдөрлөг” амжилттай зохион байгуулсан. Тус өдөрлөгийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын хэлтэс оролцож, иргэдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэн, эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ хүргэлээ. 	
4.1.3	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн		Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл,	800 Иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн.	980-аас доошгүй иргэн даатгуулагчдад	980-аас доошгүй иргэн даатгуулагчдад мэдээлэл	Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын фэйсбүүк хуудсыг тогтмол ажиллуулж, олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж байна. Тус хуудас нь нийт 2.1 мянган дагагчтай бөгөөд ЭМДЕГ-ын албан	80

	хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.		хандалтын тоо		мэдээлэл хүргэсэн байна.	хүргэсэн байна.	ёсны хуудсанд байршуулсан мэдээллүүдийг тогтмол хуваалцаж, иргэд болон эрүүл мэндийн байгууллагуудад даатгалын талаарх мэдээ, мэдээллийг хүргэн сурталчилгаа хийж байна. Мөн хэлтсээс бэлтгэн боловсруулсан 7 төрлийн контент-ыг өөрсдийн хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж, сурталчилгааны ажлыг идэвхтэй явуулсан. Үүний зэрэгцээ, хэлтсийн байранд биечлэн хандаж ирсэн нийт 378 иргэнд эрүүл мэндийн даатгалын талаарх шаардлагатай мэдээллийг шууд хүргэн, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан болно.	
4.1.4	БГТ 4.1.8 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.		Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	272 иргэн судалгаанд хамрагдсан	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн байгууллагын сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг идэвхжүүлэх зорилгоор урамшуулан дэмжих, мэдээлэл түгээх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд Говь-Алтай аймгийн хэмжээнд нийт 38 эрүүл мэндийн байгууллага сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан. Цаашид судалгаанд хамрагдах иргэд болон байгууллагын тоог нэмэгдүүлэх, судалгааны үр дүнгийн чанарыг сайжруулах зорилгоор аймгийн хэмжээнд дотоод идэвхжүүлэлтийн ажлыг шат дараатайгаар зохион байгуулахаар төлөвлөж байна.	60

4.1.5	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.		Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлт ийн хувь	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 25, шийдвэрлэлт 100 хувь.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт ийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт ийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	<p>2025 оны 3-р улирлын байдлаар нийт 14 иргэний хурууны хээний материалыг хүлээн авч, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тамгын газарт дотоод албан бичгээр хүргүүлэн, шийдвэрлүүлсэн. Шийдвэрийн хариуг иргэдэд утсаар мэдэгдэж, өргөдөл, гомдол, хүсэлтүүдийг холбогдох хууль, журмын дагуу хугацаанд нь бүрэн шийдвэрлэн ажиллалаа.</p> <p>Мөн тус аймгийн хэмжээнд 1111 төвөөр дамжуулан утсаар ирсэн эмийн сантай холбоотой нэг гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэсэн.</p> <p>И-баримтаар эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ буруу төлсөн нийт 11 иргэний өргөдлийг хүлээн авч, холбогдох хэлтэст шилжүүлэн 100 хувь шийдвэрлэсэн.</p>	80
4.1.6	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллана.		Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт 16 удаа гаргаж тайлагналт 100 хувь	Удирдах дээд газараас өгөгдсөн үүрэг даалгаварыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Удирдах дээд газараас өгөгдсөн үүрэг даалгаварыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын санаачилгаар долоо хоног бүрийн хоёр дахь өдөр зохион байгуулагддаг шуурхай хуралд хэлтсийн дарга тогтмол оролцож, хуралдаанаас өгсөн мэдээлэл, чиглэлийг хэлтсийн мэргэжилтнүүдэд цаг алдалгүй хүргэж, гарсан шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Шуурхай хурлаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг тухай бүрт нь нэгтгэн гаргаж, ЭМДЕГ-т хүргүүлдэг.	80

4.1.7	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон хэлтсийн дотооддоо хийж гүйцэтгэсэн ажлуудын хэрэгжилтийг хангаж биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.		Үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь	-	Үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтсээс ирүүлсэн хариутай албан бичиг, судалгаа, тайлан болон бусад шаардлагатай мэдээллийг хугацаанд нь чанартай боловсруулж, хүргүүлэн ажиллаж байна. Долоо хоног бүр зохион байгуулагддаг шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг нийт 16 өгсөн бөгөөд орон нутгийн хэлтэст хамааралтай үүрэг даалгавар 10 удаа холбогдох мэргэжилтэнд тогтмол хүргүүлэн ажилласан болно. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй хурал, цуглаан, судалгаа, сургалт, мод тарих аян, "Нээлттэй хаалганы өдөр" зэрэг нэгдсэн арга хэмжээнд хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд идэвх санаачилгатайгаар оролцож байна.	80
4.1.8	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	Төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээг үндэслэн хэлтсийн гурван мэргэжилтэнтэй гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гэрээ байгуулж, хагас болон бүтэн жилийн хугацаанд түүний хэрэгжилтийг үнэлэн дүгнэж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Ажилтнуудын цаг бүртгэлд тогтмол хяналт тавьж, ажлын ачааллыг оновчтой хуваарилах замаар бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Мөн мэргэжлийн түвшинд зөвлөн туслах, шаардлагатай үед чиглэл өгч,	80

				хүргүүлэн ажилласан.			ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэйгээр удирдан зохион байгуулж байна.	
4.1.9	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.		Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо	2024 онд 72 бодь хадгаламжийн нэгж хүргүүлсэн	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	2024 онд 18 анхан шатны баримтыг архивын нэгж болгон бүрэн хадгалсан. Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтад оролцож, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллаж байна. 2025 оны 3 дугаар сарын байдлаар 3 архивын нэгжийг бүрэн үдэж, архивт хадгалсан байна. .	80
4.1.10	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.		-Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, - Хэрэгжилтийн хувь	-	Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.	Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.	- 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай хууль хэрэгжиж байгаа тул албан бичгүүдийг монгол бичиг болон кирилл бичгээр зэрэг хөтлөн явуулж байна. - Үүний дагуу нийт 19 албан бичгийг хос бичгээр боловсруулсан байна. - Мөн хэлтсийн зүгээс 175,000 төгрөгийн өртөг бүхий кирилл үсэгээс монгол бичиг рүү хөрвүүлэх зориулалттай ухаалаг маойз төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.	80

4.1.11	Цахим гарын үсгийг байгууллагын ажиллагаанд үйл бүрэн нэвтрүүлнэ.		Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо	-	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2025 оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Тоон гарын үсэг ашиглах” сургалтад хамрагдаж, ABLE системд тоон гарын үсэг холбох, ашиглах талаар мэдээлэл, зааварчилгаа авсан. Үүний дагуу албан бичиг, баримтыг тоон гарын үсгээр баталгаажуулан ашиглаж байна. Мөн TridumKey Client программ хангамжийг компьютерт суулгаж, найман албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан тогтмол хэрэглэн ажиллаж байна.	80
4.1.12	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана		Хэрэгжилтийн хувь	Хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ-ээ 100 хувь мэдүүлсэн байна.	Хэрэгжилтийг ханган ажилласан байна	Хэрэгжилтийг ханган ажилласан байна	Хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд 2024 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг (ХАСХОМ) хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж, цахим системээр мэдүүлсэн.	100
5. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд								
5.1	Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судлаж, танилцан бүрэн мэдлэгтэй болно.		Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх	Тогтоолын шинэчлэлтэй холбоотой 6 удаагийн сургалтанд хамрагдсан.	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан 03, 04 дүгээр тогтоолын шинэчлэлтэй холбоотой цахим сургалтад нийт 7 удаа хамрагдаж, бүрэн судлан танилцсан. Үүнтэй зэрэгцэн 03, 04 дүгээр тогтоолын агуулгаар эрүүл мэндийн байгууллагуудад зориулсан	80

							танхимын сургалтыг 3 удаа зохион байгуулан, мэдээлэл хүргэсэн.	
5.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана		Хамрагдсан сургалтын тоо	Нийт цахим болон тахимын 41 удаагийн сургалтад хамрагдсан.	ЭМДЕГ-аас батласан сургалтын хөлөбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтанд бүрэн хамрагдаж мэдлэг мэдээлэл авсан байна.	ЭМДЕГ-аас батласан сургалтын хөлөбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтанд бүрэн хамрагдаж мэдлэг мэдээлэл авсан байна .	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас долоо хоног бүрийн гурав дахь өдөр зохион байгуулдаг "Мэдээллийн цаг" цахим уулзалт, сургалтад 5 удаа хамрагдаж, эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ мэдээлэл авсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим болон танхимын нийт 19 удаагийн сургалтад хамрагдаж, төрийн албаны ёс зүй, хууль эрх зүй, төрийн үйлчилгээний чанар хүртээмж зэрэг чиглэлээр мэдлэгээ нэмэгдүүлсэн. Үүнээс гадна, орон нутгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтуудад хамрагдсан бөгөөд Эрүүл мэндийн газраас "Эрүүл шүд – Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад оролцож, хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах талаар мэргэжлийн мэдээлэл, арга зүйг судалсан.	80
5.3	Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал , хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад		Хамрагдсан сургалтын тоо	Сургалт семинарт бүрэн хамрагдсан байна.	Сургалт семинарт бүрэн хамрагдсан байна.	Сургалт семинарт бүрэн хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөл орон нутаг ажиллах үеэр аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулсан танхимын сургалтад хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэрэглээ, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, мөн хувь хүний	80

	хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлнэ.						хөгжлийн чиглэл зэрэгээр мэдээлэл авсан.	
5.4	Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах		Хамрагдсан сургалтын тоо	Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилсэн байна.	Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	Хэлтсийн үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор 175,000 төгрөгийн өртөг бүхий, кирилл үсгээс монгол бичиг рүү хөрвүүлэх зориулалттай ухаалаг маойз төхөөрөмж худалдан авч, өдөр тутмын ажилд ашиглаж байна. Тус төхөөрөмжийг үр бүтээлтэй ашиглахын тулд хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд монгол бичгийн хэрэглээ, хөрвүүлгийн арга зүйтэй холбоотой сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн.	80

Төлөвлөгөөг үнэлсэн:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Төсвийн шууд захирагч

C. Энхболд

/С.ЭНХБОЛД/

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

Нэгжийн дарга

Б.Оюунцэцэг

/Б.ОЮУНЦЭЦЭГ/

20250624

Тайлагнасан:
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга

Б. Энхцэцэг

/Б.ЭНХЦЭЦЭГ/

